



ХУЛД СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ч.ЗОРИГТБААТАР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.01.18 № 01/02

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Аудитын газрын 2017 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Хулд сумын тусгай зориулалтын сангуудад санхүүгийн аудит хийх явцад 143,806,441.00 /Нэг зуун дөчин гурван сая найман зуун зургаан мянга дөрвөн зуун дөчин нэг/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Сангийн 273,000.00 /хоёр зуун далан гурван мянга/ төгрөгийн өвсийг зориулалт бусаар зарцуулж, бараа материал акталсны зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Монгол улсын засгийн газрын 374 дүгээр тогтоолын “Мал хамгаалах сангийн хөрөнгийг захиран зарцуулах, тайлагнах журам”-ын 2.9.5-д /сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, эзэлийн эргэн төлөх үйл ажиллагаанд хяналт тавих/ заасныг зөрчсөн байна.

2. Жилийн эцсийн байдлаар нийт 143,533,441.00 /Нэг зуун дөчин гурван сая таван зуун гучин гурван мянга дөрвөн зуун дөчин нэг/ төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6-д /Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах/ заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.4-т /Байгууллага, иргэдтэй үүссэн материаллаг дүнтэй буюу насжилт өндөртэй авлага, өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй/, 4.1.7-д /Хууль тогтоомж зөрчсөн

0000000003

алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Зориулалт бусаар зарцуулсан хөрөнгийг сангийн дансанд буцаан төвлөрүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх;
2. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх;
3. Хугацаа хэтэрсэн авлагыг бууруулах, хууль, хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх;
4. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 03 дугаар сарын 05-ны дотор аймгийн Аудитын газарт ирүүлэхийг Хулд сумын Засаг дарга Ч.Зоригтбаатар, нягтлан бодогч Ч.Хүүхэнбаатар нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

ШИНЖЭЭЧ



Ж.УГТАХБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

ХУЛД СУМЫН ЗАСАГ

ДАРГА



Ч.ЗОРИГТБААТАР

НЯГТЛАН БОДОГЧ

Ч.ХҮҮХЭНБААТАР

¹ Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/